Орхон аймгийн ЗДТГазар

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2015 оны 01-р сарын 19-ний өдөр

1. 2014 онд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлуудын тайланг видео болон гэрэл зургаар баримтжуулж архивт хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулах:

- **Биелэлт:** 2014 онд хийгдсэн хөрөнгө оруулалттай холбоотой ажлуудын гэрэл зураг, видео хэлбэрээр хийгдсэн танилцуулга, тайлан, телевизийн нэвтрүүлэгүүдийг цуглуулж архивлах ажлыг хийж байна.

2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг яамдуутай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан саналуудтай уялдуулж төлөвлөгөө гаргах, зарим хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар холбогдох яамдтай хамтарч ажиллах:

- Биелэлт: Аймгийн 2015 оны үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг яамдын сайдтай аймгийн Засаг даргын байгуулах гэрээнд тусгуулахаар хүргүүлсэн.

3. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг ил тод болгон цахим хуудсанд байршуулж, уг хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын дэргэдэх шуурхай зөвлөгөөн дээр тогтмол танилцуулж байх :

Биелэлт :

Аймгийн хэмжээнд төрийн сангаар гүйлгээ хийгддэг нийт 112 байгууллага бүртгэлтэйгээс босоо удирдлагатай 32, орон нутгийн болон тусгай шилжүүлгийн 80 байгууллага байна.

Шилэн дансны тухай мэдээлэлийг орон нутгийн байгууллагууддаа дараах хэлбэрээр танилцуулсан.

- Тухайн төсвийн байгууллагад утсаар мэдээлэл өгөх
- Шилэн дансны тухай хууль, цахим хуудсанд тавигдах мэдээлллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, гарын авлагыг ажил мэргэжилдээ хэвшүүлэх
- Сангийн яамны 260663, 263156 утасанд холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авах
- Бүх төсвийн байгууллага болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын менежер, нягтлан бодогчдыг хамруулсан шилэн дансны тухай хуулийн талаар Сангийн яамны мэргэжилтнүүд ирж сургалт зохион байгуулсан.

Erdenet.mn сайтан дээр шилэн дансны цэс нь доорх байдлаар харагдаж байгаа байдал.

4. 2015 онд хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын зураг төсөв хийлгэх, эрэмбэлэх асуудлыг зохион байгуулж, танилцуулах

- **Биелэлт: Хотын захирагчийн алба, Санхүү төрийн сангийн хэлтэстэй санал солилцож зураг төсөв, хөрөнгө оруулалтын ажлуудыг эрэмбэлэх асуудлыг зохион байгуулан ажиллаж байна.**

Анхаарал тавьсанд баярлалаа

2015 ОНЫ 01-Р САРЫН 19-НЫ ӨДӨР